

Газрын тосны ашиглалтын хэлтэс
2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл-ийн хувь	
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		Өөрийн үнэлгээ	ХШҮ
Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ									
1.1.	Газрын тосны ордын ашиглалт, олборлолтыг урт хугацаанд тогтвортой хадгалж, боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж, дэмжлэг үзүүлнэ	Үйл ажиллагааны зардлаар	Экспортын хэмжээ	4.1 сая баррель буюу 552.8 мянган тонн	4.2 сая баррель буюу 579.0 мянган тонн		Гэрээлэгчдийн 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаарх газрын тосны олборлолтын хэмжээ 3.45 сая баррель буюу 312.5 мянган тонн байна.	82.1%	80%
1.1.1	Олборлож буй тосны тоо хэмжээнд газар дээр нь хяналт тавих.	Үйл ажиллагааны зардлаар	Олборлолтын хэмжээ	4.2 сая баррель буюу 568.7 мянган тонн	1.8 сая баррель буюу 247.3 мянган тонн	4.2 сая баррель буюу 579.0 мянган тонн	Ашигт малтмал, газрын тосны газрын даргын баталсан Томилолтын удирдамжийн дагуу 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Газрын тосны ашиглалтын хэлтсийн мэргэжилтнүүд Дорнод аймгийн Матад сумын нутагт орших Тосон-Уул XIX, Халхгол сумын нутагт орших	95%	90%

						<p>Тамсаг XXI талбай, Дорноговь аймгийн Сайншанд сумын нутагт орших БХГ97 талбайнуудад албан томилолтоор 334 хоног ажилласан. Томилолтоор ажиллах хугацаандаа тус талбайнуудаас олборлож буй газрын тосны тоо хэмжээнд өдөр бүр хяналт тавьж, бүртгэл хөтлөн удирдлагыг мэдээллээр ханган ажилласан. Петрочайна дачин тамсаг ХХК нь Тосон-Уул XIX талбайд олборлолтын тоног төхөөрөмж суурилуулсан нийт 486 цооног байгаа бөгөөд үүнээс нэгдсэн байгууламжид холбогдсон 400 цооног, холбогдоогүй 86 цооногоор хоногт дунджаар 3,853 баррель, задгайгаар буюу цооног шавхалтад ашиглаж буй 364 цооног байгаагаас 72 цооногоор хоногт дунджаар 566 баррель, нийт 4,419 баррель газрын тосыг хоногт олборлож байна. Тамсаг XXI талбайгаас 2025 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар олборлолтын тоног төхөөрөмж суурилуулсан 307</p>		
--	--	--	--	--	--	---	--	--

						<p>цооногоос 1,446,455 баррель, задгайгаар буюу цооног шавхалтаар 126,941 баррель, нийт 1,573,396 баррель буюу 216,965 тонн газрын тос олборлосон байна. Доншен Газрын тос (Монгол) ХХК нь БХГ97 талбайгаас 2025 онд 429,000 баррель буюу 60,000 тонн газрын тос олборлож, экспортлох төлөвлөгөөтэй байгаагаас 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар олборлолтын тоног төхөөрөмж суурилуулсан цооногуудаас 347,071 баррель буюу 48,541 тонн газрын тос олборлосон. БХГ-97 талбайд олборлолтын тоног төхөөрөмж суурилуулсан нийт 188 цооног байгаа бөгөөд үүнээс дунджаар 129 цооногоор хоногт дунджаар 1283 баррель олборлож байна. Гэрээлэгчдийн 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаарх олборлосон тосны хэмжээ 3.47 сая баррель буюу 469.22 мянган тонн байна. Энэ оны жилийн олборлолт хүлээгдэж буй</p>	
--	--	--	--	--	--	---	--

							гүйцэтгэл буюу 2025 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар 3.78 сая баррельд хүрэх тооцоотой байна.		
1.1.2	Экспортолж буй тосны тоо хэмжээ, чанарын шинжилгээнд газар дээр нь байнгын хяналт тавьж ажиллах	Үйл ажиллагааны зардлаар	Экспортын тоо хэмжээ	4.1 сая баррель буюу 552.8 мянган тонн	1.8 сая баррель буюу 247.3 мянган тонн	4.1 сая баррель буюу 579.0 мянган тонн	Ашигт малтмал, газрын тосны газрын даргын баталсан Томилолтын удирдамжийн дагуу 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Газрын тосны ашиглалтын хэлтсийн мэргэжилтнүүд Дорнод аймгийн Матад сумын нутагт орших Тосон-Уул XIX, Халхгол сумын нутагт орших Тамсаг XXI талбай, Дорноговь аймгийн Сайншанд сумын нутагт орших БХГ97 талбайд албан томилолтоор нийт 334 хоног ажилласан бөгөөд экспортолж буй газрын тосны тоо хэмжээ, чанарын шинжилгээнд тухай бүрд хяналт тавьж, бүртгэл хөтлөн, удирдлагыг мэдээллээр ханган ажилласан. Тосон-Уул XIX талбайгаас 2025 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар нийт 1,437,655 баррель буюу 190,816 тонн газрын тосыг БНХАУ-д экспортлоод байна. Тосон-Уул XIX	95%	90%

						<p> талбайгаас өдөрт дунджаар 18 автоцистернээр 4,315 баррель тосыг экспортолсон бөгөөд дундаж усны агуулга 0.025 хувь, нягт 834.2 кг/м3 байна. Тамсаг XXI талбайгаас 2025 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар өдөрт дунджаар 19 автоцистернээр 1,554,669 баррель буюу 214,788 тонн газрын тосыг БНХАУ руу экспортлоод байна. Экспортолж буй газрын тосны дундаж усны агуулга 0.03 хувь, нягт 866.7 кг/м3 байна. БХГ97 талбайгаас 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 35 удаагийн ачилтаар 276,466 баррель буюу 40,148 тонн газрын тосыг БНХАУ-д экспортолсон байна. Экспортолсон тосны дундаж усны агууламж 0.025 хувь, 15 градус дахь нягт 885.4 кг/м3 байна. Гэрээлэгчдийн экспортлосон газрын тосны нийт хэмжээ 2025 оны 11 дүгээр сарын 30- ны өдрийн байдлаар 3.26 сая баррель буюу 444.27 мянган тонн байна. Энэ </p>		
--	--	--	--	--	--	--	--	--

							оны жилийн экспорт хүлээгдэж буй гүйцэтгэл буюу 2025 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар 3.57 сая баррельд хүрэх тооцоотой байна.		
1.1.3	Экспортолж буй тосны чанарын шинжилгээ, ачилт, буулгалтын тоо хэмжээнд хяналт тавьж бүртгэл хөтлөх.	Үйл ажиллагааны зардлаар	Пүүг хянан шалгасан тоо хэмжээ	24	12	24	Ашигт малтмал, газрын тосны газрын даргын баталсан удирдамжийн дагуу Газрын тосны ашиглалтын хэлтсийн мэргэжилтнүүд 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Дорнод аймгийн Матад сумын нутагт орших Тосон-Уул XIX, Халхгол сумын нутагт орших Тамсаг XXI, Дорноговь аймгийн Сайншанд сумын нутагт орших БХГ97 талбайнуудад албан томилолтоор 334 хоног ажилласан. Томилолтоор ажиллах хугацаандаа тус талбайнуудаас экспортолж буй газрын тосны ачилт, буулгалтын тоо хэмжээ, чанарын шинжилгээнд өдөр бүр хяналт тавьж, бүртгэл хөтлөн удирдлагыг мэдээллээр ханган ажилласан. Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайн нэгдсэн байгууламж дахь хэмжих хэрэгслийг нийт 24 удаа шалгасан.	100%	100%

							Олборлолтын ил байгууламжаас экспортолж буй түүхий тосны хэмжилтийг гүйцэтгэдэг авто машины пүүний хэвийн ажиллагааг шалгах ажлыг 14 хоногт 1 удаа шалгах хувиарын дагуу зохион байгуулсан. Гаалийн хяналтын пүү болон дотоодын тээвэрлэлтэд ашиглаж байгаа пүүнүүдийг цаг тухайд нь тохируулж баталгаажуулсан бөгөөд MNS 5311:2003 стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнд байсан. БХГ97 талбайгаас 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн байдлаар 35 удаагийн ачилтаар 276,466 баррель буюу 38,947 тонн газрын тосыг БНХАУ-д экспортолсон бөгөөд усны агууламж 0.025%, 15 градус дахь нягт 885.4 кг/м3 байна.		
1.1.4	Гэрээлэгчдийн гадаад ажиллах хүч, мэргэжилтэн Монгол улсад хөдөлмөр эрхлэхтэй холбоотой асуудлыг эрх бүхий байгууллагаар	Үйл ажиллагааны зардал	Гаргасан тодорхойлолтын тоо	3	-	3	Петрочайна Дачин Тамсаг ХХК-иас 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 25/2-958 дугаар албан бичгээр “БХГ-т Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайн гадаад ажиллах хүч,	100%	70%

	шийдвэрлүүлэхэд дэмжлэг үзүүлэх.						мэргэжилтний хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн хугацааг 2025-2026 онд сунгуулах, 2026 онд шинээр хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авах тухай” хүсэлт ирүүлснийг судалж, хүсэлтийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагад уламжилсан. Мөн Доншен газрын тос (Монгол) ХХК-иас 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 389/25 дугаар албан бичгээр “БХГ-97 талбайн гадаад ажилчдын хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл 2026 онд сунгуулах тухай” хүсэлт ирүүлснийг судалж, хүсэлтийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагад 2025 оны 12 дугаар сард багтаан уламжлахаар ажиллаж байна.		
1.1.5	Газрын тосны ашиглалтын үйл ажиллагаатай холбоотой холбогдох хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилт, бодлогын баримт бичиг,	Үйл ажиллагааны зардал	Гаргасан тайлан, мэдээллийн тоо	15	6	15	Газрын тосны салбарт ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй компаниудын тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх саналыг боловсруулж Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдад хүргүүлсэн. Мөн газрын тосны хайгуул,	100%	100%

	<p>нээлттэй өгөгдлийн мэдээ мэдээлэл, хэлтсийн төлөвлөгөө, тайланг тухай бүр боловсруулж, холбогдох газар, хэлтэст хүргүүлэх.</p>					<p>ашиглалтын үйл ажиллагаанд хууль бусаар саад учруулж буй төрийн бус байгууллага, иргэдийн талаарх мэдээллийг Цагдаагийн Ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газарт тус тус хүргүүлсэн. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн А/73 дугаар тушаалаар байгуулагдсан “Петрочайна дачин тамсаг” ХХК-ийн үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлаар Хятадын талын ажлын хэсэгтэй хэлэлцээ хийх, хамтран ажиллах, холбогдох асуудлаар зөвшилцөх, үр дүнг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдад танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг мэдээллээр хангах, холбогдох мэдээ тайлан, бичиг баримт, материалыг нэгтгэх, санал, танилцуулга боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/63 дугаар тушаалаар батлагдсан</p>		
--	---	--	--	--	--	--	--	--

						“Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд Ашигт малтмал, газрын тосны газар болон Үндэсний геологийн албанаас мэдээ, тайлан ирүүлэх журам”-ын дагуу газрын тосны олборлолт, экспортын 7 хоногийн тоон мэдээг гарган ХШҮДАГ-т, Аж үйлдвэр, эрдэс баялагийн яамны Газрын тосны бодлогын газарт цахим шуудангаар, мөн сар бүрийн олборлолт, экспортын мэдээг Үндэсний статистикийн хороонд цахимаар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд албан бичгээр тус тус хүргүүлэн ажилласан.		
Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ								
3.1.	Газрын тосны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах, Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан үйл ажиллагааг явуулж буй аж ахуйн нэгжид хяналт тавина.	Үйл ажиллагааны зардал	Гэрээний тоо	4	4	Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/06 дугаартай тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллаж “Петрочайна дачин тамсаг” ХХК-ийн Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайн бүтээгдэхүүн хуваах гэрээний 2024 оны хэрэгжилтийг 2025 оны	100%	100%

							02 дугаар сарын 27-ны өдөр, “Доншен газрын тос (Монгол)” ХХК-ийн БХГ97 талбайн гэрээний 2024 оны хэрэгжилтийг 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдөр, “Петроматад” ХХК-ийн Матад ХХ талбайн гэрээний 2024 оны хэрэгжилтийг 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдөр тус тус дүгнэж баталгаажуулсан.		
3.1.1	Тосон-Уул XIX, Тамсаг XXI, 1997 оны БХГ-т, Матад ХХ талбайн 2025 оны ажлын төлөвлөгөөний гүйцэтгэлийг гэрээлэгчтэй тулган баталгаажуулах	Үйл ажиллагааны зардал	Төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэлийн тоо хэмжээ	4	4	4	Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/06 дугаартай тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг: “Петрочайна дачин тамсаг” ХХК-ийн Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайн 2024 оны ажлын төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэлийг 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдөр, “Доншен газрын тос (Монгол)” ХХК-ийн БХГ97 талбайн 2024 оны ажлын төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэлийг 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдөр, “Петроматад” ХХК-ийн Матад ХХ талбайн 2024 оны ажлын төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэлийг 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдөр	100%	100%

							тус тус гэрээлэгчтэй хэлэлцэн тулгаж баталгаажуулсан.		
3.1.2	Тосон-Уул XIX, Тамсаг XXI, Матад XX, 1997 оны Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн Бүтээгдэхүүн хуваах гэрээний 2024 оны хэрэгжилтийн тайланг гэрээлэгчидтэй хэлэлцэн дүгнэх.	Үйл ажиллагааны зардал	Бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилтийн тоо	4	4	4	Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/06 дугаартай тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг: “Петрочайна дачин тамсаг” ХХК-ийн Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайн бүтээгдэхүүн хуваах гэрээний 2024 оны хэрэгжилтийг 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдөр, “Доншен газрын тос (Монгол)” ХХК-ийн БХГ97 талбайн бүтээгдэхүүн хуваах гэрээний 2024 оны хэрэгжилтийг 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдөр, “Петроматад” ХХК-ийн Матад XX талбайн бүтээгдэхүүн хуваах гэрээний 2024 оны хэрэгжилтийг 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдөр тус тус дүгнэсэн.	100%	100%
3.1.3	Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайгаас 2024 онд олборлосон шингэн, үүнээс ус, тос, хийн хэмжээ, экспортолсон тосны тоо хэмжээ,	Үйл ажиллагааны зардал	Байгуулсан протоколын тоо хэмжээ	3	4	4	Бүтээгдэхүүн хуваах гэрээт Тосон-Уул XIX, Тамсаг XXI, БХГ97 талбайн 2024 онд олборлосон шингэн, үүнээс ус, тос, хийн хэмжээ, экспортолсон тосны тоо хэмжээ,	100%	100%

	<p>үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашигласан усны хэмжээг гэрээлэгчидтэй тулган баталгаажуулах.</p>					<p>үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашигласан усны хэмжээг тулган баталгаажуулсан. БХГ-т Тосон-Уул XIX талбайгаас 2024 онд олборлолтын цооногуудаас 1,644,088.18 баррель буюу 218,691.31 тонн түүхий тос, шавхалтаар 202,246.15 баррель буюу 26,636.23 тонн түүхий тос, 6,571 автоцистернээр 1,767,323 баррель буюу 234,837 тонн түүхий тосыг экспортолсон. Ус шахалтанд 2,540,627 м3, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд 2,184,833 м3 ус ашигласан. Тамсаг XXI талбайгаас 2024 онд олборлолтын цооногуудаас 1,832,964.20 баррель буюу 252,547.49 тонн түүхий тос, шавхалтаар 173,640.56 баррель буюу 23,926.10 тонн түүхий тос, 7,281 автоцистернээр 1,947,767 баррель буюу 268,580 тонн түүхий тосыг экспортолсон. Ус шахалтанд 2,229,079 м3, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд 2,232,581 м3 ус ашигласан байна.</p>		
--	---	--	--	--	--	--	--	--

							Тамсаг XXI талбайн Та-2 олборлолтын нэгдсэн байгууламжаас 4,541,153 м3 хий ялгаснаас 4,186,475 м3 хийг халаах зууханд, 354,678 м3 хийг цахилгаан генераторт тус тус ашигласан байна. БХГ97 талбайгаас 2024 онд олборлолтын цооногуудаас 338,087.00 баррель буюу 47,284.90 тонн түүхий тос, 877 вагонцистернээр 357,146.13 баррель буюу 50,236.88 тонн түүхий тосыг экспортлон, ус шахалтанд 284,767 м3 усыг ашигласан байна.		
3.1.4	Газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа гэрээлэгчдээс ирүүлсэн жилийн ажлын төлөвлөгөө, төсвийн төслийг судалж, санал дүгнэлт гаргаж, батлуулах	Үйл ажиллагааны зардал	Ажлын төлөвлөгөө, төсвийн тоо хэмжээ	4	4	4	Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/06 дугаартай тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг: “Петрочайна дачин тамсаг” ХХК-ийн Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайн 2025 оны ажлын төлөвлөгөө, төсвийн төсөлд санал, дүгнэлт өгч, төлөвлөгөө, төсвийг 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдөр, “Доншен газрын тос (Монгол)” ХХК-ийн БХГ97 талбайн 2025 оны ажлын төлөвлөгөө, төсвийг 2025	100%	100%

							оны 02 дугаар сарын 21-ний өдөр, “Петроматад” ХХК-ийн Матад ХХ талбайн 2025 оны ажлын төлөвлөгөө, төсвийг 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдөр тус тус батлуулсан.			
3.1.5	Тосон-Уул, Тамсаг, Цагаан-Зүүнбаян, Элсний тосны ашиглах ажиллагааны төлөвлөгөөний нэмэлт тодотголын төслийг гэрээлэгчид зөвлөмж хүргүүлэх.	Тамсаг, Цагаан-газрын ордыг үйл зардал	Үйл ажиллагааны зардал	Орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөний нэмэлт тодотголд гаргасан санал дүгнэлтийн тоо	2	-	3	Петрочайна дачин тамсаг ХХК-ийн зүгээс Тосон-Уул, Тамсагийн газрын тосны ордыг ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөний нэмэлт тодотголын төсөлд өөрчлөлт оруулж, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэхээр тодотголын төслийг ирүүлсэн боловч тус төсөл нь 2012 онд батлагдсан Орд ашиглалтын төлөвлөгөөний үзүүлэлтүүдээс хэт зөрүүтэй байсан тул баталгаажуулах боломжгүй байсан. Үүнтэй холбогдуулан эхний ээлжинд Тосон-Уул, Тамсагийн газрын тосны ордын нөөцийн тооцооны тайлангийн тодотгол, дахин тооцооллын ажлыг гүйцэтгэхээр болсон. Газрын тосны орд	100%	100%

							ашиглах төлөвлөгөө нь батлагдсан нөөцийн үндсэн дээр хийгддэг тул эхлээд тус ордуудын нөөцийн тооцооны тайлангийн тодотгол, дахин тооцоолол гүйцэтгэх нь зүйтэй гэж үзсэн ба гэрээлэгч компани хөндлөнгийн байгууллагаар тухайн ажлыг гүйцэтгүүлж байна. Мөн Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн зүгээс Зүүнбаян, Цагаан-Элсний ордын газрын тосны нөөцийн дахин тооцооллын тайланг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэхээр ирүүлсэн ба тус тайлан батлагдсаны дараа ордыг ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөний тодотголыг ирүүлнэ.		
3.1.6	Гэрээлэгчээс ирүүлсэн Тосон-Уул, Тамсаг, Зүүнбаян, Цагаан-Элс, Цэн Тогоруу газрын тосны ордын нөөцийн хөдөлгөөний тайланг хянаж, санал дүгнэлт гаргах.	Үйл ажиллагааны зардал	Хянасан тайлангийн тоо	3	-	4	Уул уурхай, хүнд үйлдвэрийн Сайдын 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн А/287 дугаар тушаалаар баталсан “Газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлага” журмын дагуу Тосон-Уул, Тамсагийн газрын тосны ордын нөөцийн тооцооны	100%	100%

							тайлангийн тодотгол, дахин тооцооллын ажлыг гүйцэтгэж байна. Петрочайна дачин тамсаг ХХК болон нөөцийн үнэлгээ гүйцэтгэж буй компанийн нөөцийн тодотголын төслийг 2024 оны 12 дугаар сард урьдчилсан байдлаар танилцуулсан бөгөөд өнөөдрийн байдлаар гэрээлэгчийн зүгээс монгол хэл рүү хөрвүүлэх ажлыг гүйцэтгэж байна. Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн хувьд Зүүнбаян, Цагаан-Элсний ордын газрын тосны нөөцийн дахин тооцооллын тайлангийн төслийг засаж, сайжруулах ажлыг гүйцэтгэж, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг гүйцэтгэж байна.		
3.1.7	Газрын тосны ашиглалтын талбайнуудад 2025 онд хийж гүйцэтгэх ажлуудын мэдээг АМГТГ-ын даргын 2022 оны 01 дүгээр сарын 31-ний А/17 дугаар тушаалаар баталсан мэдээний	Үйл ажиллагааны зардал	Албан томилолтоор ажилласан хоног	328	120	240	Ашигт малтмал, газрын тосны газрын даргын баталсан томилолтын удирдамжийн дагуу 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Газрын тосны ашиглалтын хэлтсийн мэргэжилтнүүд Дорнод аймгийн Матад сумын нутагт орших	100%	100%

	<p>загварын дагуу хүлээн авч, хянан үзэх, бүртгэл хөтлөх, гүйцэтгэлд хяналт тавих.</p>					<p>Тосон-Уул XIX, Халхгол сумын нутагт орших Тамсаг XXI талбай, Дорноговь аймгийн Сайншанд сумын нутагт орших БХГ97 талбайд албан томилолтоор нийт 334 хоног ажилласан. Томилолтоор ажиллах хугацаандаа тус талбайд хийгдэж буй цооног үйлчилгээний болон ашиглалтын цооногийн хэмжилт, туршилтын үйл ажиллагаанд газар дээр нь хяналт тавьж, АМГТГ-ын даргын 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/17 тушаалаар баталсан мэдээний загварын дагуу тайланг хүлээн авч, бүртгэл хөтөлсөн. БХГ-т Тосон-Уул XIX талбайд 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар 214 цооногийн засвар үйлчилгээний ажил хийж гүйцэтгээд байна. БХГ-т Тосон-Уул XIX талбайд 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар нийт 545 удаагийн хэмжилт, туршилтын ажлыг хийж гүйцэтгэсэн. БХГ-т Тамсаг XXI талбайд 2025 12 дугаар 05-ны өдрийн байдлаар 121 цооногт засвар үйлчилгээний</p>		
--	--	--	--	--	--	--	--	--

							ажил хийж гүйцэтгээд байна. БХГ-т Тамсаг XXI талбайд 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар нийт 460 удаагийн хэмжилт, туршилтын ажлыг хийж гүйцэтгэсэн болно. БХГ97 талбайд 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар 134 цооногт засвар үйлчилгээний ажлыг гүйцэтгэсэн бөгөөд үүнээс шахуурга шалгах ажлыг 74 удаа хийж гүйцэтгэсэн.		
3.1.8	Тосон-Уул XIX, Тамсаг XXI, Матад XX, 1997 оны БХГ-т талбайд 2024 онд хийж гүйцэтгэсэн ажлын анхдагч мэдээ, материалыг нэгтгэн боловсруулах	Үйл ажиллагааны зардал	Нэгтгэж гаргасан ботийн тоо	51	18	36	Бүтээгдэхүүн хуваах гэрээт газрын тосны ашиглалтын Тосон-Уул XIX, Тамсаг XXI, БХГ97, Матад XX талбайд 2024 онд хийж гүйцэтгэсэн ажлуудын анхдагч мэдээ, материалыг нэгтгэн боловсруулсан бөгөөд БХГ-т Тосон-Уул XIX талбайн 102 боть, Тамсаг XXI талбайн 96 боть, БХГ97 талбайн 50 боть, Матад XX талбайн 1 боть материалыг тус тус архивлан, байгууллагын архивт хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулсан.	100%	100%
3.1.9	Газрын тосны ашиглалтын талбайнуудад 2024	Үйл ажиллагааны зардал	Хүлээн авсан тайлангийн тоо хэмжээ	90	-	75	Газрын тосны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д "Гэрээлэгч	100%	100%

	<p>онд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг Уул уурхайн сайдын 2015 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 49 дугаар тушаалаар батлагдсан "Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын анхдагч болон үр дүнгийн тайланд тавигдах шаардлага" журмын дагуу хянаж, хүлээн авах.</p>						<p>хайгуул, ашиглалтын ажлын үр дүнгийн тайлан, анхдагч мэдээ материалыг хуанлийн тухайн жил дууссанаас хойш 90 хоногийн дотор төрийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгнө.", "Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын анхдагч болон үр дүнгийн тайланд тавигдах шаардлага" журмын 10 дугаар зүйлийн 10.1-д "Ашиглалтын үйл ажиллагааны үеийн төлөвлөгөө, мэдээ, тайлан, материалыг Хүснэг-7-д заасны дагуу ирүүлнэ.", 14 дүгээр зүйлийн 14.5-д "Тайлан монгол болон англи хэл дээр бичигдсэн байна.", 15 дугаар зүйлд "Судалгааны ажлуудын тайланг 6 сарын дотор ирүүлнэ." гэж тус тус заасны дагуу ажлын үр дүнгийн тайлан болох 90 ширхэг тайланг хянаж, хүлээн авсан.</p>		
3.1.10	<p>Гэрээлэгчдийн өртөг нөхөгдөх зардлын тайланг хүлээн авах нэгтгэх.</p>	<p>Үйл ажиллагааны зардал</p>	<p>Өртөг нөхөгдөх зардлын тайлангийн тоо хэмжээ</p>	14	6	12	<p>Гэрээлэгчдийн 2024 оны IV дүгээр улирлын өртөг нөхөгдөх зардлын тайланг хүлээн авч нэгтгэв: Ашиглалтын 3</p>	100%	100%

						<p>гэрээлэгчийн 4 талбайд 2024 оны өртөг нөхөгдөх зардлын тайлангаар 180.5 сая ам.доллар, Хайгуулын 8 гэрээлэгчдийн 9 талбайн нийт 20.0 сая ам.долларыг өртөг нөхөгдөх зардлын тайланд тайлагнасныг хүлээн авч нэгтгэв. Нийт дүнгээр 2024 оны хөрөнгө оруулалтын хэмжээ 205.2 сая ам.доллар: үүнээс өртөг нөхөгдөх зардлын хэмжээ 200.5 сая ам.доллар. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 32.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна. 2025 оны I, II, III дугаар улирлын өртөг нөхөгдөх зардлын тайланг хүлээн авч нэгтгэв: Ашиглалтын 3 гэрээлэгчийн 4 талбайд 48.8 сая ам.доллар, Хайгуулын 9 гэрээлэгчдийн 11 талбайд нийт 10.0 сая ам.долларыг өртөг нөхөгдөх зардлын тайланд тайлагнасныг хүлээн авч нэгтгэв. Өртөг нөхөгдөх зардлын тайлангийн хяналт, шалгалтаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгуулах зөвлөмжийг</p>		
--	--	--	--	--	--	--	--	--

						<p>2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 3/2002, 08 дугаар сарын 12-ны өдрийн 3/3880, 10 дугаар сарын 6-ны өдрийн 3/4805, 10 дугаар сарын 09-ний 3/4918, 11 дүгээр сарын 28-ны 3/5915,12 дугаар сарын 03-ны өдрийн 3/6088, 3/6089, 3/6090, 3/6091, 3/6092, 3/6093, 3/6094 дугаартай албан бичгүүдээр гэрээлэгчдэд хүргүүлсэн. Нийцлийн аудитын ашиглалт, хайгуулын тайланд тусгагдсан зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 1/436, 1/487 дугаар албан бичиг, биелэлтийг 01 дүгээр сарын 29-ний өдрийн 1/494, 05 дугаар 19-ний өдрийн 1/2419, 09 дүгээр сарын 01-ний өдрийн 1/4228, 10 дугаар сарын 09-ний өдрийн 1/4924 дугаар албан бичгээр ҮАГ-т хүргүүлсэн. Хайгуулын 2023 оны асуудлын бүртгэлийн төсөлтэй танилцан холбогдох хариу санал, тайлбарыг ирүүлэх</p>	
--	--	--	--	--	--	--	--

							1/2646, 1/2647, 1/2648, 1/2649, 1/2650, 1/2651, 1/2652 дугаартай албан бичгүүдийг гэрээлэгчдэд хүргүүлсэн. Холбогдох хариу санал тайлбарыг нэгтгэн 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 1/2874 дугаар албан бичгээр УАГ-т хүргүүлсэн.		
3.1.11	Гэрээлэгчдийн өртөг нөхөгдөх болон нөхөгдсөн зардлын тооцоонд хяналт, шалгалт хийх, дүгнэлт гаргах.	Үйл ажиллагааны зардал	Гаргасан дүгнэлтийн тоо	14	-	12	АМГТГ-ын даргын 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/114 дүгээр тушаалаар газрын тосны ашиглалтын Петроматад ХХК-ийн Матад ХХ, Петрочайна дачин тамсаг Тосон Уул XIX, Тамсаг XXI, Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн БХГ 97 талбайн 2023 онд батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх болон нөхөгдсөн зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтын тайланг анхан шатны баримтад үндэслэн хяналт, шалгалтыг хийж, дүгнэлтийн төслийг 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 3/153, 2025 оны 08 дугаар сарын 05-	100%	90%

						<p>ны өдрийн 3/3769, 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 3/4532 дугаар албан бичгүүдээр гэрээлэгчдэд хүргүүлсэн. Ашиглалтын 3 гэрээлэгчийн 4 талбайн хяналт, шалгалтын дүгнэлт, тайланг 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 1/2105, 08 дугаар сарын 28-ны өдрийн 1/4158, 10 дугаар сарын 20-ны өдрийн 1/5087 дугаартай албан бичгүүдээр УАГ-т хүргүүлсэн. АМГТГ-ын даргын 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/82 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг газрын тосны хайгуулын Капкорп Монголиа ХХК-ийн Онги V, Макс ойл ХХК-ийн Арбулаг ХХИХ, Смарт ойл Монголиа Эргэлт-ХИИ, Жи Өү Эйч ХХК-ийн Номгон IX, Тахь ресурс ХХК-ийн Богд IV, Онги V, Метан газ ресурс ХХК-ийн Таван толгой ХХХИИИ, Монголын алт "МАК" ХХК-ийн Төхөм Х, Тэлмэн ресурс ХХК-ийн Гурвантэс-ХХХV талбайнуудын 2024 онд батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил,</p>	
--	--	--	--	--	--	---	--

							хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх зардлын тайланг анхан шатны баримтад үндэслэн хяналт, шалгалтыг хийж, дүгнэлтийн төслийг 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 3/5279, 3/5280, 3/5281, 11 дүгээр сарын 10-ны өдрийн 3/5519, 3/5535, 3/5533, 3/5534 11 дүгээр сарын 25-ны өдрийн 3/5860 дугаартай албан бичгүүдээр гэрээлэгчдэд хүргүүлсэн. Хяналт, шалгалт хийх тухай 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 3/2270 албан бичгийг хайгуулын 12 гэрээлэгчдэд хүргүүлсэн. Хайгуулын 12 гэрээлэгчийн 14 талбайн 2024 оны хяналт, шалгалтын дүгнэлт, тайланг УАГ-т хүргүүлсэн.		
3.1.12	Тосон-Уул XIX, Матад XX, Тамсаг XXI, 1997 оны БХГ-т талбайн 2025 оны “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-ний хэрэгжилтэд хяналт тавих.	Үйл ажиллагааны зардлаар	Батлагдсан менежментийн төлөвлөгөөний тоо хэмжээ	4	4	4	Петрочайна дачин тамсаг ХХК-ийн Тосон Уул XIX талбайн 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2025 оны 05 дугаар сард, Тамсаг XXI талбайн 2025 оны менежментийн төлөвлөгөө 2025 оны 06 дугаар сард, Доншен газрын тос (Монгол) ХХК-	100%	100%

							ийн 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2025 оны 06 дугаар сард, Петроматад ХХК-ийн Матад ХХ талбайн 2025 оны менежментийн төлөвлөгөө 2025 оны 08 дугаар сард БОАЖЯ-аар тус тус хянагдан батлагдсан. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төсөлд тусгагдсан ажлуудыг батлагдсан ажлын төлөвлөгөө, төсөвтэй уялдсан эсэхийг хянаж, холбогдох мэргэжилтнүүд батлагдсан БОМТ-ны дагуу хийгдэж буй ажлуудад газар дээр нь тогтмол хяналт тавин ажилласан.		
3.1.13	Тосон-Уул, Тамсаг, Зүүнбаян, Цагаан-Элс, Цэн-Тогоруу ордод олборлолтын дэд байгууламж, хуваарилах станц, цооног хоорондын шугам хоолой, цахилгаан дамжуулах шугам, авто зам барих ажилд хяналт тавьж, хамтран ажиллах.	Үйл ажиллагааны зардал	Талбайд хяналт тавьж ажилласан хоног	41	20	45	АМГТГ-ын хөдөө орон нутагт ажиллах удирдамжуудийн дагуу 2025 онд Тосон-Уул, Тамсаг, Зүүнбаян, Цагаан-Элс, Цэн-Тогоруу ордуудын бүтээн байгуулалтын ажилд газар дээр нь холбогдох мэргэжилтнүүд хяналт тавьж ажиллаа. Олборлолтын барилга, байгууламж, дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн газрын тосны	100%	100%

						<p>ашиглалтын талбайд нийт 84 хоног томилолтоор хяналт тавьж, дараах ажлуудыг баримтжуулсан: Тосон-Уул XIX талбайд газрын тосны ус шахалтын 1 цооног тэдгээрийн шугам хоолой, цахилгааны холболтыг гүйцэтгэж ашиглалтад шинээр оруулсан, Тамсаг XXI талбайд газрын тосны олборлолтын 1 цооногийг олборлолтод шилжүүлсэн, ус шахалтын 2 цооног тэдгээрийн шугам хоолой, цахилгааны холболтыг гүйцэтгэж ашиглалтад шинээр оруулсан байна. Мөн БХГ-т 1997 талбайд олборлолтын 5 хуучин цооногийг сэргээж, засварлаж олборлолтод шилжүүлсэн, ус шахалтын 3 цооногийг тоноглож танк фармд холбосон, тос хадгалах 5000 м3 -ийн 2 савны холболтын ажлыг тус тус гүйцэтгэсэн байна. Матад XX талбайд газрын тосны 2 цооногт олборлолтын тоног төхөөрөмж суурилуулж, 1.2 км 10 киловольт ЦДАШ, 10:04 250 кВт чадалтай дэд</p>		
--	--	--	--	--	--	--	--	--

							станцыг угсарч, суурьлуулаад байна.		
3.2.	Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу төлөх төлбөр урамшуулал, орлогыг тооцож, нэхэмжлэн төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагааны зардлаар	Орлогын хэмжээ	237.8 тэрбум төгрөг	347.9 төгрөг	тэрбум	Холбогдох хууль, журам, бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тостой холбогдсон үйл ажиллагаанаас Улсын төсөвт нийт 210.8 тэрбум төгрөг төвлөрүүлсэнээс газрын тосны экспортын орлого 205.4 тэрбум төгрөг, бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу төлсөн төлбөр, урамшуулал 5.2 тэрбум төгрөг байна.	61%	70%
3.2.1	Гэрээлэгчдийн борлуулсан түүхий тосны орлого, зардал, нөөц ашигласны төлбөр, өртөгт газрын тос, ашигт газрын тос, Монгол Улсын Засгийн газарт ногдох орлогын тайлан тооцоог хүлээн авч, нэгтгэх.	Үйл ажиллагааны зардлаар	Орлогын хэмжээ	237.8 тэрбум төгрөг	173.9 тэрбум төгрөг	347.9 тэрбум төгрөг	Монгол Улсын 2025 оны батлагдсан төсвөөр газрын тосны орлогыг 347.9 тэрбум төгрөг гэж төлөвлөсөн ч Улсын төсөвт тодотгол оруулсанаар 2025 оны газрын тосны орлогыг 249.7 тэрбум төгрөг болгож өөрчилсөн. Энэ оны газрын тосны орлого 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар 205.5 тэрбум төгрөг буюу 82.3% гүйцэтгэлтэй байна. Үүнээс Петровичайна Дачин Тамсаг ХХКомпани 193.8 тэрбум төгрөг, Доншен газрын тос /Монгол/ ХХКомпани 11.6 тэрбум	92.3%	70%

						<p>төгрөг төвлөрүүлсэн байна. Хүлээгдэж буй гүйцэтгэл 2025 оны 12-р сарын 31-ны байдлаар 218.6 тэрбум төгрөг төвлөрүүлэх тооцоотой байна. Газрын тосны орлогоос нөөц ашигласны төлбөрийг тооцвол Петрочайна Дачин Тамсаг ХХКомпани 29.5 тэрбум төгрөг, Доншен газрын тос /Монгол/ ХХКомпани 3 тэрбум төгрөг байна. Монгол улсын Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 05 дугаар тогтоолоор баталсан Нөөц ашигласны төлбөр болон тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах журмын 2.5, 3.5-д заасны дагуу газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгч компаниудын 2025 онд төлөгдсөн газрын тосны нөөц ашигласны төлбөр, тусгай зөвшөөрлийн төлбөрийн хуваарилалтын тооцоог 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 1/5251 дугаар албан бичгээр, 2025 оны 12</p>		
--	--	--	--	--	--	--	--	--

							дугаар сарын 05-ны өдрийн албан бичгээр тус тус Сангийн Яаманд хүргүүлэв. "Петроматад" ХХК, "Петрочайна Дачин Тамсаг" ХХК, "Доншен газрын тос"/Монгол/ ХХК-ны газрын тосны орлогын тайланг хүлээж авч нэгтгэв.		
3.2.2	Гэрээлэгчдийн бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу төлөх тусгай зөвшөөрлийн төлбөр, сургалтын урамшуулал, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэг төлбөрийг Газрын тосны тухай хууль болон гэрээнд заасан хугацаа, талбайн хэмжээ зэргээс хамааруулан тухай бүр тооцож, нэхэмжлэн төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах.	Үйл ажиллагааны зардлаар	Төлбөрийн хэмжээ	3.0 тэрбум төгрөг	1.1 тэрбум төгрөг	2.2 тэрбум төгрөг	Хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу төлөх төлбөр, урамшууллыг гэрээнд заасан хугацаанд "төлбөр төлөх тухай" 2025 оны 1 дүгээр сарын 28 -ны өдрийн 3/399, 3/400,03/401, 3/402, 3/403, 3/403, 3/404, 3/405, 3/406, 3/407, 3 дугаар сарын 20-ны өдрийн 3/1325, 3/1326, 11 дүгээр сарын 03-ны өдрийн 1/5365, 1/5366, 1/5367, 1/5368, 1/5369, 1/5370, 1/5371, 06-ны өдрийн 1/5450, 1/5451, 1/5452, 1/5453, 1/5472, 1/5472 дугаартай албан бичгүүдийг гэрээлэгчдэд хүргүүлэв. БХГ-ний дагуу гэрээлэгчид 2025 онд улсын төсөвт нийт 5.3 тэрбум төгрөг төвлөрүүлсэнээс Тусгай зөвшөөрлийн 1.4 тэрбум	100%	100%

						<p>төгрөг, Сургалтын урамшууллын 1.9 тэрбум төгрөг, Төлөөлөгчийн газрыг дэмжих санд 1.9 тэрбум төгрөг тус тус төвлөрүүлсэн байна. - Ашигт малтмал, газрын тосны газрын 2026 оны төсвийн орлогыг Газрын тосны орлого болон газрын тосны тусгай зөвшөөрлийн тооцоог сар тус бүрээр тооцоолон гаргав. - Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжих хөрөнгийн 2026 оны төлөвлөгөөнд өгөх саналыг нэгтгэн хэрэгцээт бараа материал эд хөрөнгийн үнийн судалгааг хийж гаргав.</p>		
3.1.	<p>Газрын тосны ашиглалтын салбарын талаар орон нутагт салбарын мэдээлэл, сурталчилгааг түгээх, мэдлэг олгох сургалт зохион байгуулах, иргэд олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулна.</p>	<p>Үйл ажиллагааны зардлаар</p>	<p>Зохион байгуулсан арга хэмжээний тоо</p>	0	2	<p>Дорнод аймгийн засаг дарга асан М.Бадамсүрэн нь 2018 оны 9 дүгээр сард 1 сарын турш газрын тосны экспортын тээврийг орон нутагт үр өгөөжгүй гэж үзэн зогсоож, нутгийн захиргааны байгууллага болон иргэдийн төлөөлөгчдийн шаардлагаар орон нутагтай хамтран ажиллах чиглэлээр 2018.10.29-ний өдөр АМГТГ, Дорнод аймгийн</p>	100%	70%

							Засаг дарга болон Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн хооронд “Гурван талт хэлцэл” түүний “Тэмдэглэл”-ийг 2019-2023 он дуустал 5 жилийн хугацаатайгаар харилцан үзэглэсэн байдаг. Энэхүү Гурван талт хэлцлийн хугацаа дуусгавар болсонтой холбогдуулан Дорнод аймгийн ЗДТГ-аас удаа дараа гэрээг сунгах хүсэлт ирүүлсэнээр 2019-2023 оны Гурван талт хэлцэл, түүний тэмдэглэлийн хэрэгжилтийг гаргаад байна. Гэвч Гурван талт хэлцлийг дүгнэх уулзалтын товыг орон нутгаас хойшлуулсан.		
3.1.1	Орон нутагт салбарын мэдээлэл, сурталчилгааг түгээх, мэдлэг олгох сургалт зохион байгуулах, иргэд олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулна.	Үйл ажиллагааны зардлаар	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	0	-	2	Газрын тосны хайгуул, олборлогчдын холбоо ГҮТББ-тай хамтран 2025 оны 9-р сарын 12-ны өдөр Mining week-2025 чуулганд газрын тосны салбарын хайгуул, олборлолтын үйл ажиллагааг суртчилан таниулах салбар хэлэлцүүлгийг зохион байгуулсан. АМГТГ-аас Газрын тос, байгалийн хийн хайгуул, олборлогчдын холбоотой	100%	70%

						<p>хамтран газрын тосны салбарын орон нутгийн уулзалт, хэлэлцүүлгийн бэлтгэл ажлыг ханган, "Зүүн бүсийн зөвлөлдөх уулзалт"-ыг 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Чойбалсан хотноо зохион байгуулах саналыг Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газарт 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 1/1771 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Гэвч Дорнод аймгийн Засаг даргаас ирүүлсэн хүсэлтийн дагуу хойшлуулсан. Мөн Дорнод аймагт үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгч компаниудын өгсөн саналын дагуу 2026 оны 2 дугаар улиралд газрын тосны салбарыг орон нутагт сурталчлан таниулах, хэлцлийг дүгнэх хурлыг зохион байгуулахаар болсон.</p>		
<p>Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ</p>								
4.1.	Салбарын чиглэлээр мөрдөгдөж буй хууль бусад хууль тогтоомжийн төсөлд санал өгөх, төслийн хувилбар боловсруулна.	Үйл ажиллагааны зардлаар	Нийт хүргүүлсэн саналаас Хууль журамд нийцүүлэн хүргүүлсэн саналын эзлэх хувиар	100%	100%	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-	100%	100%

					<p>ийн 2.1.3.5-д “Хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоог бий болгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, ирээдүйд ахмад настнууд олон эх үүсвэрээс тэтгэвэр авах боломжийг бүрдүүлнэ” зорилтын хүрээнд “Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль”-ийн төсөлтэй танилцан temuujin@mflsp.gov.mn цахим хаягаар саналаа хүргүүлсэн. Газрын тосны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах дэд ажлын хэсэг 2025 оны 6 дугаар сарын 25-26 ны өдрүүдэд хуулийн төсөлд санал хүргүүлж ажилласан. МУ-ын Засгийн Газрын 2025 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаас гарсан үүрэг даалгаварын хүрээнд газрын тосны салбарт тулгамдаж буй асуудлын талаар танилцуулгыг бэлтгэн, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулсан. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн А/194 дүгээр тушаалаар баталсан</p>	
--	--	--	--	--	---	--

							“Газрын тосны бүртгэл, тооцооны журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай журмын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг”-ийн хуралдаанд оролцож, холбогдох саналаа хүргүүлж ажилласан.		
4.1.1	УИХ, Монгол улсын Засгийн газраас салбарын чиглэлээр батлан гаргах тогтоол шийдвэрийн төсөлд санал өгч ажиллах	Үйл ажиллагааны зардлаар	Нийт хүргүүлсэн саналаас Хууль журамд нийцүүлэн хүргүүлсэн саналын эзлэх хувиар	100%	100%	100%	АҮЭБЯ-наас 2025 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 07/2229 тоот албан бичгээр “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-аас газрын тосны хайгуулын Давст ХХХI талбайд БНХАУ-ын “Петрочайна Дачин Тамсаг” ХХК болон “Дачин Чемпион” компаниудтай хайгуул, ашиглалтын чиглэлээр хамтран ажиллах гурван талт гэрээний төсөлд санал өгөх чиглэлийн дагуу гэрээний төсөлд санал боловсруулж 2025 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 3/4015 тоот албан бичгээр хариу хүргүүлж, санал боловсруулсан. АМГТГ болон Хятадын газрын тосны их сургуультай 2023 онд байгуулсан “Хамтран ажиллах” гэрээг шинэчлэн, хоёр талаас санал авч нэгтгэн	100%	100%

							<p>боловсруулсан. Уг гэрээнд бакалаврт элсэн сурах оюутнуудыг газрын тосны технологич инженер, химийн инженер, байгаль орчны нөхөн сэргээлт, компьютер технологи гэсэн ангиудад шинээр элсүүлэх, АМГТГ-ын албан хаагчдад зориулсан богино хугацааны сургалтыг боловсруулах, хамрагдуулах, мөн эрдмийн зэргийн (бакалавр, магистр, доктор) сургалтын төлбөрийг 2017-2023 онуудад АМГТГ-т 20%-ийн хөнгөлөлт үзүүлж байсныг 40% болгох санал боловсруулж, “Хамтран ажиллах” гэрээг 2025 оны 7 дугаар сарын 2-ны өдөр шинэчлэн байгуулсан.</p>		
4.1.2	Ашигт малтмалын салбарт мөрдөх дүрэм, журам, заавар, аргачилсан зөвлөмжийг боловсруулахад оролцох	Үйл ажиллагааны зардлаар	Нийт хүргүүлсэн саналаас Хууль журамд нийцүүлэн хүргүүлсэн саналын эзлэх хувь.	100%	100%	100%	<p>Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/18 дугаар тушаалаар байгуулагдсан Газрын тосны тухай хуулийг шинэчлэх ажлын хэсгийн хуралд 4 удаа оролцон холбогдох саналыг өгч ажилласан. Аж үйлдвэр, эрдэс</p>	100%	100%

						<p>баялгийн сайдын 2025 оны 06 дугаар сарын 04-ны өдрийн А/144, 2025 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн А/194 дугаар тушаалаар байгуулагдсан Газрын тосны бүртгэл, тооцооны журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай журмын төсөл боловсруулах ажлын хэсгийн хуралд 4 удаа оролцож тухай бүр саналаа өгч ажилласан. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн А/208 дугаар тушаалаар байгуулагдсан “Петрочайна дачин тамсаг” ХХК болон “Доншен газрын тос (Монгол)” ХХК-тай байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийн хэрэгжилтэд тулгамдаж байгаа асуудлыг судалж, цаашид баримтлах чиглэлээр санал боловсруулан танилцуулах үүрэг бүхий Дэд ажлын хэсэгт холбогдох санал, дүгнэлт боловсруулсан. Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн Петрочайна Дачин Тамсаг ХХК-тай байгуулах техникийн</p>	
--	--	--	--	--	--	--	--

						<p>гэрээнд санал өгөх чиглэлийг АҮЭБЯ-аас ирүүлсэний дагуу Монгол ГТБҮ ТӨХХК-ийн холбогдох мэргэжилтэнүүдтэй хэлэлцүүлэн, дээрх гэрээний төсөлд санал өгч, АҮЭБЯ-нд хүргүүлсэн. Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт баригдаж буй газрын тос боловсруулах үйлдвэрт түүхий тос тээвэрлэн хүргэх газрын тос дамжуулах хоолойг Дорнод аймгийн Тосон-Уул XIX талбайн Та-1 нэгдсэн байгууламжид холбох ажлын угсралтын бэлтгэлийг хангах техникийн хуралд оролцож, хэлэлцсэн асуудал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний тухай дөрвөн талын протокол байгуулсан.</p>		
--	--	--	--	--	--	---	--	--

Үнэлсэн:

.....

(албан тушаал)

.....

(гарын үсэг)

/...../

.....

(огноо)

Тайлагнасан:

.....

.....

(албан тушаал)

.....

(гарын үсэг)

/...../

.....

(огноо)

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Тамсагийн ордын олборлолт, хадгалалт, тээвэрлэлт хариуцсан мэргэжилтэн, Амгаланбаатар Ёндонсүрэн

2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.1. Газрын тосны ордын ашиглалт, олборлолтыг урт хугацаанд тогтвортой хадгалж, боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж, дэмжлэг үзүүлнэ							
1	Олборлож буй тосны тоо хэмжээнд газар дээр нь хяналт тавих.	Олборлолтын хэмжээ	4.2 сая баррель буюу 568.7 мянган тонн	4.2 сая баррель буюу 579.0 мянган тонн	2025 оны жилийн эцсийн байдлаар 2025.01.06-01.20, 2025.02.03-02.17, 2025.03.19-04.02, 2025.05.07-05.21, 2025.08.29-09.12, 2025.10.20-11.13-ны хооронд тус тус нийт 84 хоног БХГ-г Тамсаг XXI талбайд албан томиллоор олборлож буй тосны тоо, хэмжээнд хяналт тавин ажилласан. Тамсаг XXI талбайгаас 2025 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар олборлолтын тоног төхөөрөмж суурилуулсан цооногоор 1,446,455 баррель, задгайгаар буюу цооног шавхалтаар 126,941 баррель, нийт 1,573,396 баррель буюу 216,965 тонн газрын тос	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					олборлосон байна. Тус талбайд олборлолтын тоног төхөөрөмж суурилуулсан нийт 316 цооног байгаа бөгөөд үүнээс нэгдсэн байгууламжид холбогдсон 302 цооног, холбогдоогүй 14 цооногоор хоногт дунджаар 4,130 баррель, задгайгаар буюу цооног шавхалтад ашиглаж буй 82 цооногоор хоногт дунджаар 376 баррель, нийт 4,506 баррель газрын тосыг олборлож байна. Олборлож буй тосны дундаж нягт 809.9 кг/м3 бөгөөд усны агуулга 73 хувьтай байна.		
2	Экспортолж буй тосны тоо хэмжээ, чанарын шинжилгээнд газар дээр нь байнгын хяналт тавьж ажиллах	Экспортын тоо хэмжээ	4.1 сая баррель буюу 552.8 мянган тонн	4.1 сая баррель буюу 579.0 мянган тонн	2025 оны жилийн эцсийн байдлаар 2025.01.06-01.20, 2025.02.03-02.17, 2025.03.19-04.02, 2025.05.07-05.21, 2025.08.29-09.12, 2025.10.20-11.13-ны хооронд тус тус нийт 84 хоног БХГ-т Тамсаг XXI талбайд албан томилолтоор экспортолж буй тосны тоо хэмжээ, чанарын шинжилгээнд хяналт тавин ажилласан. 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 1,554,669 баррель буюу 214,788 тонн газрын тосыг БНХАУ руу БХГ-т Тамсаг XXI талбайгаас экспортлоод байна. Албан томилолтоор ажиллах хугацаандаа газрын тосны экспортын ачилтын мэдээг хүлээн авч, бүртгэл хөтөлж, удирдлагыг мэдээллээр ханган	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 95% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					ажилласан. . Өдөрт дунджаар 18 автоцистернээр 4,730 баррель тосыг БНХАУ-д экспортолж байна. Экспортолж буй газрын тосны усны агуулга 0.025 хувь, дундаж нягт 866.7 кг/м3 байна. Экспортолж буй газрын тосны хэмжээ, чанарын шинжилгээнд Гаалийн ерөнхий газрын байцаагч, хөндлөнгийн хяналтын Амбер ХХК давхар хяналт тавин ажиллаж байна.		
3	Экспортолж буй тосны чанарын шинжилгээ, ачилт, буулгалтын тоо хэмжээнд хяналт тавьж бүртгэл хөтлөх.	Пүүг хянан шалгасан тоо хэмжээ	24	6	2025 оны жилийн эцсийн байдлаар 2025.01.06-01.20, 2025.02.03-02.17, 2025.03.19-04.02, 2025.05.07-05.21, 2025.08.29-09.12, 2025.10.20-11.13-ны хооронд тус тус нийт 84 хоног БХГ-т Тамсаг ХХI талбайд албан томилолтоор ажиллах хугацаанд буулгалтын цэгт буусан газрын тосны тоо хэмжээ, чанарын шинжилгээг хянаж, бүртгэл хөтөлж ажилласан. Та-2 Олборлолтын нэгдсэн байгууламж дахь хэмжих хэрэгслийг 6 удаа шалгасан. Пүүний хэвийн ажиллагаа: Петрожайна Дачин Тамсаг ХХК-ийн БХГ-т Тамсаг ХХI талбайн Та-2 олборлолтын нэгдсэн байгууламжаас экспортолж буй түүхий тосны хэмжилтийг гүйцэтгэдэг авто машины пүүний хэвийн ажиллагааг шалгах ажлыг 14 хоногт 1 удаа шалгах хувиарын дагуу зохион байгуулж	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					ажилласан. Гаалийн хяналтын пүү болон дотоодын тээвэрлэлтэд ашиглаж байгаа пүүнүүдийг шалгахад 0-20 кг зөрүү үүссэн бөгөөд пүүнүүдийг цаг тухайд нь тохируулж баталгаажуулсан бөгөөд MNS 5311:2003 стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнд байсан.		
1.2. Газрын тосны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах, Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан үйл ажиллагааг явуулж буй аж ахуйн нэгжид хяналт тавина.							
